



I-IX/2021


Тархаасан: 2021 оны 10 дугаар сарын 14



## Улсын нэгдсэн төсөв

Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2021 оны эхний 9 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 11.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 3.8 (52.2%) их наяд төгрөг, тэнцвэржүүлсэн орлого тусламжийн хэмжээ 9.7 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 3.0 (44.2%) их наяд төгрөгөөр тус тус өссөн байна.

ЗУРАГ 1. УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО, ЗАРЛАГА, ТЭНЦЭЛ, жил бүрийн эхний 9 сарын байдлаар, тэрбум төгрөг



Нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 10.9 их наяд төгрөг болж, тэнцвэржүүлсэн тэнцэл 1.3 их наяд төгрөгийн алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеэс 1.5 (53.3%) их наяд төгрөгөөр буурсан байна.

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн хэмжээ 2021 оны 9 дүгээр сард 1.1 их наяд төгрөг болж, өмнөх сараас 281.7 (32.6%) тэрбум төгрөг, нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 1.4 их наяд төгрөг болж, өмнөх сараас 306.5 (28.5%) тэрбум төгрөгөөр тус тус өсжээ.


Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2021 оны 7 дугаар сард 238.9 тэрбум төгрөгийн ашигтай гарсан бол 8 дугаар сард 211.2 тэрбум төгрөг, 9 дүгээр сард 236.1 тэрбум төгрөгийн алдагдалтай байна.

Улсын нэгдсэн төсвийн орлогод тогтворжуулалтын сангийн орлогын эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 4.4 нэгж хувь, татварын бус орлого 2.1 нэгж хувь, ирээдүйн өв сангийн орлого 0.4 нэгж хувиар тус тус өсөж, татварын орлого 6.8 нэгж хувиар буурсан байна.

Татварын нийт орлого 2021 оны эхний 9 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 8.5 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.4 (39.6%) их наяд төгрөгөөр өсөхөд орлогын албан татвар 1.2 (83.3%) их наяд төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвар 462.4 (28.6%) тэрбум төгрөг, нийгмийн даатгалын орлого 305.6 (24.8%) тэрбум төгрөг, бусад татвар, төлбөр хураамжийн орлого 207.8 (39.3%) тэрбум төгрөг, гадаад үйл ажиллагааны орлого 149.0 (27.1%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.


Татварын нийт орлого 2021 оны 9 дүгээр сард 978.3 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 195.4 (25.0%) тэрбум төгрөгөөр өсөхөд орлогын албан татвар 109.7 (2.2 дахин) тэрбум төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвар 46.9 (19.1 %) тэрбум төгрөг, бусад татвар, төлбөр хураамжийн орлого 42.7 (61.3%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ. Харин онцгой албан татвар 24.0 (26.2 %) тэрбум төгрөг, тусгай зориулалтын орлого 0.7 (39.6%) тэрбум төгрөгөөр буурчээ.

ЗУРАГ 2. УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ТАТВАРЫН ОРЛОГЫН БҮТЭЦ, дүнд эзлэх хувиар



Татварын нийт орлогод орлогын албан татварын эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 7.4 нэгж хувиар өсөж, нийгмийн даатгалын орлогынх 2.1 нэгж хувь, онцгой албан татварынх 2.0 нэгж хувь, нэмэгдсэн өртгийн албан татварынх 2.1 нэгж хувь, гадаад үйл ажиллагааны орлогынх 0.8 нэгж хувь, бусад татварынх 0.4 нэгж хувиар тус тус буурсан байна.

ЗУРАГ 3. УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ТАТВАРЫН БОЛОН ТАТВАРЫН БУС ОРЛОГО, НИЙТ ЗАРЛАГА, ЦЭВЭР ЗЭЭЛ, жил бүрийн эхний 9 сарын байдлаар, тэрбум төгрөг




Улсын нэгдсэн төсвийн зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2021 оны эхний 9 сард байдлаар 10.9 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.5 (15.9%) их наяд төгрөгөөр өссөн байна.

Зарлагын өсөлтөд урсгал зардал өмнөх оны мөн үеэс 1.8 (23.7%) их наяд төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна. Харин хөрөнгийн зардал 358.8 (18.6%)

тэрбум төгрөгөөр буурсан байна.

Улсын нэгдсэн төсвийн зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2021 оны 9 дүгээр сард 1.4 их наяд төгрөг болж, өмнөх сараас 306.5 (28.5%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Үүнд урсгал зардал 205.6 (24.6%) тэрбум төгрөг, хөрөнгийн зардал 130.5 (58.3%) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

ЗУРАГ 4. УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН УРСГАЛ ЗАРДЛЫН БҮТЭЦ,  
дүнд эзлэх хувиар



Урсгал зардалд урсгал шилжүүлгийн эзлэх хувь 2021 оны эхний 9 сард өмнөх оны мөн үеэс 12.2 нэгж хувиар өсөж, бараа үйлчилгээний зардлынх 10.4 нэгж хувь, хүүгийн зардлынх 1.4 нэгж хувь, татаас 0.4 нэгж хувиар тус тус буурсан байна.

Хөрөнгийн зардал 2021 оны эхний 9 сарын байдлаар 1.6 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 358.8 (18.6%) тэрбум төгрөгөөр буурахад барилга, байгууламжийн зардал 197.0 (16.5%) тэрбум төгрөг, тоног төхөөрөмжийн зардал 105.4 (39.7%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлжээ.

Хөрөнгийн зардалд бусад хөрөнгийн зардлын эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 3.1 нэгж хувь, барилга байгууламжийн зардлынх 1.6 нэгж хувиар өсөж, харин тоног төхөөрөмжийн зардлынх 3.6 нэгж хувь, их засварын зардлынх 0.8 нэгж хувь, стратегийн нөөц хөрөнгийн зардал 0.3 нэгж хувиар тус тус буурчээ.


Хөрөнгийн зардалд 2021 оны 7 дугаар сард 133.9 тэрбум төгрөг, 8 дугаар сард 223.9 тэрбум төгрөг, 9 дүгээр сард 354.4 тэрбум төгрөг зарцуулсан нь өмнөх сараас 130.5 (58.3%) тэрбум төгрөгөөр өсжээ. Сүүлийн 3 сарын байдлаар сар бүр хөрөнгийн зардал өсжээ.

Орон нутгийн төсөв

ЗУРАГ 5. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН  
ОРЛОГО, ЗАРЛАГА, ТЭНЦЭЛ,  
жил бүрийн эхний 9 сарын байдлаар, тэрбум төгрөг

Орон нутгийн төсвийн орлого 2021 оны эхний 9 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 2.6 их наяд төгрөг, зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээл 1.9 их наяд төгрөг болж, орон нутгийн тэнцвэржүүлсэн тэнцэл 681.7 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа.

Орон нутгийн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн ашиг өмнөх оны мөн үеэс 427.2 (2.7 дахин) тэрбум төгрөгөөр нэмэгджээ.



Орон нутгийн төсвийн орлого өмнөх оны мөн үеэс 308.5 (13.3%) тэрбум төгрөгөөр өсөхөд татварын орлого 283.8 (33.4%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

Орон нутгийн нийт төсвийн орлого, тусламжийн хэмжээ 2021 оны 9 дүгээр сард 340.0 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 78.3 (29.9%) тэрбум төгрөг, нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 275.5 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 87.4 (46.5%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

### Даатгалын сан

Нийгмийн даатгалын сангийн орлого 2021 оны эхний 9 сарын байдлаар 1.9 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 345.6 (22.4%) тэрбум төгрөг, нийт зарлага 1.9 их наяд төгрөг болж, 65.9 (3.6%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Нийгмийн даатгалын сангийн орлого өсөхөд тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого 322.0 (34.7%) тэрбум төгрөгөөр өссөн нь нь голлон нөлөөлжээ.

Нийгмийн даатгалын сангийн орлого 2021 оны 9 дүгээр сард 235.1 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 1.6 (0.7%) тэрбум төгрөг, нийт зарлага 217.3 тэрбум төгрөг болж, 2.8 (1.3%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

### ХҮСНЭГТ 3. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, жил бүрийн эхний 9 сарын байдлаар

Үзүүлэлт	2018	2019	2020	2021	2021* - IX
	I-IX	I-IX	I-IX	I-IX*	2020 I-IX
	тэрбум төгрөг				хувь
<b>Нийт орлого</b>	<b>1 488.1</b>	<b>1 761.5</b>	<b>1 542.7</b>	<b>1 888.3</b>	<b>122.4</b>
Нийгмийн даатгалын сангийн орлого	1 024.0	1 307.4	1 182.7	1 438.9	121.7
Тусламжийн орлого	464.1	454.1	360.0	449.3	124.8
<b>Нийт зарлага</b>	<b>1 345.4</b>	<b>1 531.0</b>	<b>1 830.6</b>	<b>1 896.5</b>	<b>103.6</b>
Бараа үйлчилгээний зардал	12.9	16.6	18.2	17.9	98.5
Урсгал шилжүүлэг	1 332.4	1 514.4	1 812.4	1 885.7	104.0
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	-	-	-	- 7.1	-
<b>Тэнцэл</b>	<b>142.7</b>	<b>230.5</b>	<b>- 287.9</b>	<b>- 8.2</b>	<b>2.8</b>

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 2021 оны эхний 9 сарын байдлаар 730.7 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 407.5 (2.3 дахин) тэрбум төгрөг, нийт зарлага 893.8 тэрбум төгрөг болж, 604.0 (3.1 дахин) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

### ХҮСНЭГТ 4. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, жил бүрийн эхний 9 сарын байдлаар

Үзүүлэлт	2018	2019	2020	2021	2021* - IX
	I-IX	I-IX	I-IX	I-IX*	2020 I-IX
	тэрбум төгрөг				хувь
<b>Нийт орлого</b>	<b>299.3</b>	<b>338.8</b>	<b>323.2</b>	<b>730.7</b>	<b>2.3<sup>1</sup></b>
ЭМД-ын хураамжийн шимтгэл	299.3	338.8	323.2	730.7	2.3 <sup>1</sup>
<b>Нийт зарлага</b>	<b>220.1</b>	<b>237.2</b>	<b>289.9</b>	<b>893.8</b>	<b>3.1<sup>1</sup></b>
Бараа үйлчилгээний зардал	2.1	2.6	2.6	12.7	4.9 <sup>1</sup>
Татаас	26.3	26.2	28.4	46.4	163.3
Урсгал шилжүүлэг	191.8	208.4	258.9	841.3	3.3 <sup>1</sup>
Эргэж төлөгдөх төлбөрийн хассан цэвэр зээл	-	-	-	- 6.6	-
<b>Тэнцэл</b>	<b>79.2</b>	<b>101.6</b>	<b>33.3</b>	<b>-163.1</b>	<b>-</b>

<sup>1</sup> Дахин их

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 2021 оны 7 дугаар сард 94.2 тэрбум төгрөг, 8 дугаар сард 78.1 тэрбум төгрөг, 9 дүгээр сард 75.9 тэрбум төгрөг болжээ. Сүүлийн 3 сарын байдлаар сар бүр орлого буурсан байна.

### Ойлголт, тодорхойлолт

#### **Монгол Улсын нэгдсэн төсөв**

Улсын төсөв, орон нутгийн төсөв, хүний хөгжил сангийн төсөв болон нийгмийн даатгалын сангийн төсвөөс бүрдэнэ.

#### **Тэнцвэржүүлсэн орлого**

Татварын болон татварын бус орлогоос бүрдэнэ.

#### **Орон нутгийн төсөв**

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга бүрдүүлж, зарцуулах төсөв юм.

#### **Татварын орлого**

Орлогын албан татвар, нийгмийн даатгалын орлого, хөрөнгийн албан татвар, нэмэгдэл өртгийн албан татвар, онцгой албан татвар, тусгай зориулалтын орлого, гадаад үйл ажиллагааны орлого, бусад татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ.

#### **Татварын бус орлого**

Нийтлэг татварын бус орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлого, улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгээс бүрдэнэ.

#### **Төсвийн зарлагын ангилал**

Урсгал зардал, хөрөнгийн зардал, эргэн төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл гэж ангилна. Төсвийн орлого: Ирээдүйн өв сан, тогтворжуулалтын сан болон тэнцвэржүүлсэн орлогоос бүрдэнэ.

#### **Улсын төсөв**

Улсын Их Хурлаас батлан Засгийн газар бүрдүүлж зарцуулах төсөв юм.

Урсгал зардал: Бараа, ажил, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс бүрдэнэ.

#### **Тэнцвэржүүлсэн тэнцэл**

Тэнцвэржүүлсэн орлогоос нийт зарлага, цэвэр зээлийг хасаж тодорхойлно.



### Эх үүсвэр

Сангийн яам

### Ангилал, код

Төсвийн орлого, зарлагын эдийн засгийн ангилал

### Мэдээлэл авах холбоос

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

### Дараагийн мэдээ тархаах хуваарь

2021 оны 11 дүгээр сарын 17

Эдийн засгийн статистикийн газрын

дарга А.Дэмбэрэл

Утас (976-11)-263968

Эдийн засгийн статистикийн газрын

статистикч Ч.Мөнхтуул

Утас (976-51)-264797

